



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/641

Есөнбулаг

Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Бүгд найрамдах улсыг тунхаглаж, анхдугаар үндсэн хууль баталсны 100” жилийн ойг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр улс орон даяар тэмдэглэх” тухай Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн эхний цагийн хичээлийг Монгол Улсын Үндсэн Хуулийн агуулга хөтөлбөрөөр заахыг аймгийн Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т даалгасугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (С.Мөнхжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ